



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 14

Мандалговь

Орон нутгийн өмчөөс төрийн өмчид
хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Мандалын гэгээ хот тохижуулах газар” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 53,212,700 (тавин гурван сая хоёр зуун арван хоёр мянга долоон зуу) төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй лед самбарыг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсүгэй.


2. Шилжүүлсэн хөрөнгийг Төрийн өмчийн тайлан балансад нэгтгэхийг Дундговь аймгийн Онцгой газрын дарга (Ц.Төрбилэг)-д даалгасугай.

3. Орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлэх хөрөнгийн харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (С.Хулан)-д даалгасугай.


4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн
14 тогтоолын хавсралт



“Мандалын гэгээ хот тохижуулах газар” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын
балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Лед самбар	2020.12.31	ш	1	53,212,700	53,212,700	-	
Нийт дүн					53,212,700 (тавин гурван сая хоёр зуун арван хоёр мянга долоон зуу) төгрөг	53,212,700 (тавин гурван сая хоёр зуун арван хоёр мянга долоон зуу) төгрөг		Аймгийн Онцгой байдлын газар